



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд
Санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2024/01/НА-СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Говьсүмбэр аймаг 2023 он</p>	<p>Дарга тэргүүлэх аудитор: Утас: 7054-3156 Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: govिसumber@audit.gov.mn

2024.04.19 № 63

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,354.5 сая төгрөгийн санхүүгийн зөрчил илэрсэн бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн тайланд аудит хийгээгүй Энхтусдэм өрхийн эрүүл мэндийн төвийн 640.6 сая төгрөгийн хөрөнгийн дүн нэгтгэгдсэн зөрчлийг материаллаг гэж үнэлсэн, мөн Сүмбэр, Баянтал сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан хязгаарлалттай дүгнэлт авсан нь буруу илэрхийлэл материаллаг хэдий ч өргөн тархаагүй гэж үзсэн тул аудитын дүгнэлтэд өөрчлөлт оруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дээрх зөрчлүүд нь Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар бидний тогтоосон 285.5 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Говьсүмбэр аймгийн Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль тогтоомж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсан Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллажээ.

Аудитын гол асуудал

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд

- Энхтүсдэм өрхийн эрүүл мэндийн төв татгалзсан дүгнэлт авсан;
- Баянтал, Сүмбэр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан хязгаарлалттай дүгнэлт авсан.

Бусад асуудлын хэсэг

Говьсүмбэр аймгийн ИТХ-ын хуралдааны 2024 оны 01 сарын 26-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Засаг даргын 2020-2024 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар 90.6%-ийн хэрэгжилттэй гэж дүгнэсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	11,667,836.8	15,466,828.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,730,129.4	8,997,296.6
33	АВЛАГА	1,620,855.2	1,604,121.7
34	УРЬДЧИЛГАА	78,892.8	32,863.2
35	БАРАА МАТЕРИАЛ	3,252,993.3	3,621,371.8
36	НӨӨЦИЙН БАРАА	64,663.5	86,879.4
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	1,920,302.5	1,124,295.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	30,568,522.2	35,627,918.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	30,568,522.2	35,627,918.5
39200	Биет хөрөнгө	26,194,433.7	30,766,445.9
39300	Биет бус хөрөнгө	4,374,088.5	4,861,472.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	42,236,359.0	51,094,747.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	13,302,822.5	20,470,957.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	816,001.4	2,735,829.1
41300	Өглөг	814,949.5	2,730,165.6
41400	Урьдчилж орсон орлого	1,052.0	5,663.5
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,486,821.1	17,735,128.2
42200	Урт хугацаат зээл	12,486,821.1	17,735,128.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	28,933,536.5	30,623,789.7
51	Засгийн газрын хувь оролцоо	28,933,536.5	30,623,789.7
51100	Засгийн газрын оруулсан капитал	16,822,870.6	16,822,870.6
51200	Хуримтлагдсан үр дүн	5,810,513.5	8,461,884.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,300,152.4	5,339,034.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	42,236,359.0	51,094,747.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	42,195,450.0	33,582,627.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	8,527,496.8	10,865,330.3
110	Орлогын албан татвар	6,191,780.5	8,060,437.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	6,295,632.6	7,986,926.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(263,852.1)	(317,912.7)
1103	ААН-ын орлогын албан татвар	160,000.0	391,424.0
113	Хөрөнгийн албан татвар	769,295.3	932,934.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,566,421.0	1,871,958.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,885,274.6	13,471,878.8
120	Нийтлэг татварын бус орлого	4,303,669.4	5,450,434.3
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	4,581,605.2	8,021,444.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	24,782,678.7	9,245,418.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	39,644,037.0	22,725,656.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	39,644,037.0	22,725,656.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,071,618.0	21,772,496.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,871,758.3	4,921,626.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	351,888.2	604,386.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	426,886.1	483,286.2
2104	Хангамж, бараа материалын зардал	4,603,924.5	5,176,721.8
2105	Нормативт зардал	247,606.8	157,227.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	237,109.5	368,033.9
2107	Томилолт, зочны зардал	65,071.6	136,585.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,060,168.7	6,945,382.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,207,204.3	2,979,246.9
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	1,162.0	1,138.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,571,257.0	952,021.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,551,413.0	10,856,971.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	22,978,705.0	9,037,747.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(20,427,292.0)	1,819,224.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	49,732,396.6	0.0	49,732,396.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(411,698.9)	0.0	(411,698.9)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	49,320,697.6	0.0	49,320,697.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	38,105.8	0.0	38,105.8
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,025.0	0.0	2,025.0
6	Тайлант үеийн үр дүн	(20,427,292.0)	0.0	(20,427,292.0)
7	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	28,933,536.5	0.0	28,933,536.5
8	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	28,933,536.5	0.0	28,933,536.5
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	832,147.1	0.0	832,147.1
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,765,683.5	0.0	29,765,683.5
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(961,118.0)	0.0	(961,118.0)
12	Тайлант үеийн үр дүн	1,819,224.1	0.0	1,819,224.1
13	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	30,623,789.7	0.0	30,623,789.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12- р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	48,081,148.40	35,350,457.70
11	ТАТВАРЫН ОРЛОГО	8,527,496.80	10,865,330.30
110	Орлогын албан татвар	6,191,780.50	8,060,437.90
1100	Хувь хүний орлогын албан татвар	6,295,632.60	7,986,926.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(263,852.10)	(317,912.70)
1103	ААН-ын орлогын албан татвар	160,000.00	391,424.00
113	Хөрөнгийн албан татвар	769,295.30	932,934.40
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,566,421.00	1,871,958.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	275,098.30	356,297.80
1181	Газрын төлбөр	924,150.80	709,660.20
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	367,171.80	806,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,155,923.60	15,247,866.70
120	Нийтлэг татварын бус орлого	6,574,318.40	7,226,422.20
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	4,581,605.20	8,021,444.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,397,728.00	9,237,260.70
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,921,531.30	19,227,003.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	40,921,531.30	19,227,003.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,935,023.90	18,078,829.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,680,056.20	6,418,728.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	733,904.40	1,057,293.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,415,262.70	898,794.10
2104	Хангамж, бараа материалын зардал	1,571,381.30	1,499,514.80
2105	Нормативт зардал	77,482.00	83,201.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	244,443.90	187,081.90
2107	Томилолт, зочны зардал	63,929.60	141,432.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,281,199.80	5,489,568.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,867,364.00	2,303,214.60
212	ТАТААС	1,162.00	1,138.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,985,345.40	1,147,036.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,159,617.20	16,123,454.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	9,518,578.00	11,737,846.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,518,578.00	11,737,846.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,518,578.00	11,737,846.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(9,518,578.00)	(11,737,846.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(496,485.00)	(118,440.80)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	496,485.00	118,440.80
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(2,855,445.90)	4,267,167.20
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,585,575.30	4,730,129.40
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,730,129.40	8,997,296.60

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,223,806.1	18,054,783.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,514,344.0	13,026,923.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,715,094.0	11,900,601.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,390,031.3	4,281,814.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	567,362.2	518,897.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,472,634.7	3,262,408.7
2104	Хангамж, бараа материалын зардал	278,523.2	267,938.4
2105	Нормативт зардал	3,444.4	3,010.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	359,592.1	353,352.5
2107	Томилолт, зочны зардал	154,892.7	137,107.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,371,534.0	1,213,895.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,117,079.4	1,862,176.2
212	ТАТААС	39,253.0	38,041.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	39,253.0	38,041.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,759,997.0	1,088,280.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,236,830.4	796,678.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	523,166.6	291,602.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,176,451.6	4,909,419.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	533,010.5	118,440.8
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,223,806.1	19,865,687.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,731,524.6	5,643,240.8
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,163,053.0	13,883,307.8
33	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,329,228.5	339,139.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	956,838.3
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,767,742.4
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0.0	0.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	14	14
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	202	192

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	370,457.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	368,807.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	233,224.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,960.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,495.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	
2104	Хангамж, бараа материалын зардал	6,321.1
2105	Нормативт зардал	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	
2107	Томилолт, зочны зардал	284.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	74,246.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	129,916.8
212	ТАТААС	
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	135,582.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	
2132	Бусад урсгал шилжүүлэг	80,111.0
	Олгосон санхүүжилт шилжүүлэг	55,471.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,650.0
	Дотоод эх үүсвэрээс	1,650.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	370,457.2
	Нэмэлт санхүүжилтийн орлого	370,457.2

Гурав. Аудитын илрүүлэлт: Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дарханбат, Б.Анхтуяа, аудитор С.Батцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/382 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 19,035.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 285.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Говьсүмбэр аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагч нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээ авч ажилласан байна.

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу автомашины хэрэглээг хязгаарлаж, илүүдэлтэй тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдан борлуулжээ.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/179 дүгээр захирамжаар албан тушаалын автомашин хэрэглэх эрх бүхий-4, албан ажлын-24, тусгай хэрэгцээний-28, нийт 56 авто машины жагсаалтыг гарган үүнээс 9 автомашиныг татан төвлөрүүлж дутагдалтай байгууллагад шилжүүлэх, бусад авто машиныг дуудлага худалдаагаар худалдах шийдвэр гаргасан байна.

1. Орон нутгийн өмчийн газарт бүртгэлтэй Grand Vitara маркийн /6100ГСА/ суудлын автомашиныг Баянтал суманд ашиглалтын гэрээгээр эзэмшүүлсэн.
2. АИТХД-ын 2023 оны 113-р захирамжаар Боловсрол Шинжлэх ухааны газраас УАЗ-22069 маркийн /5557ГСА/ автомашиныг Орон нутгийн өмчийн газарт бүртгэж, 2024 оноос аймгийн Гэр бүл, хүүхдийн хөгжлийн газарт ашиглалтын гэрээгээр эзэмшүүлсэн.
3. АИТХД-ын 2023 оны 115-р захирамжаар УАЗ-22069 маркийн /1813ГСА/ автомашиныг Биеийн тамир спортын газарт акталж, сэлбэг материалыг ашиглах зөвшөөрөл олгосон.
4. УАЗ-22069 маркийн 1633ГСА, УАЗ-Пример маркийн 5096ГСА, Лексус-470 маркийн 1857ГСА, Грэйс маркийн 5695ГСА, Хьондэй Старекс маркийн 5093ГСА, УАЗ-22069 маркийн 1058ГСА улсын дугаартай тээврийн хэрэгслүүдийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдаж 2023 онд 11.2 сая, 2024 онд 2.5 сая нийт 13.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

2. Төсвийн зарлагыг санхүүжүүлэхдээ хэмнэлтийн бодлого баримтлан тэвчиж болох зардлуудыг хэмнэснээр 103.4 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Эд хогшлын зардлыг 6.2 сая, дотоод албан томилолтын зардлыг 17.7 сая, бусдаар гүйцэтгүүлсэн бусад бараа ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг-48.0 сая, аймгийн Засаг

даргын хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг-31.5 сая, нийт 103.4 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг шалгахад 10 байгууллагаас 10.2 сая төгрөгийн 14 зөрчил илэрч 5.0 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 1.8 сая төгрөгийн 1 албан шаардлага, 3.3 сая төгрөгийн 7 зөвлөмж өгсөн байна. Үүнд:

1. **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ”** гэж заасныг хэрэгжүүлээгүй дараах байгууллагуудад зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн. Үүнд:
“Аймгийн ИТХ, ЗДТГ, Сүмбэр сумын ИТХ, Орон нутгийн өмчийн газар, Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ”
2. **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох”** гэж заасныг хэрэгжүүлээгүй Засгийн газрын 2023 оны 52-р тогтоолоор олгосон урамшууллыг ажилласан хугацааны үр дүнг харгалзан олгоогүй тул зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн. Үүнд:
“Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба”, “Шивээговь сумын ЗДТГ”
3. **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ”** гэж заасныг аймгийн ЗДТГ хэрэгжүүлж ажиллаагүй тул зөрчлийг давтан гаргахгүй байх 1.8 сая төгрөгийн албан шаардлага өгсөн.
4. **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”** гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй ЦСҮТ ОНӨҮГ, Шивээговь, Сүмбэр сумын ИТХ, Тохижилт Сүмбэр, Илчлэг шивээ ОНӨААТҮГ-т нийт 5.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 144 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийн хугацаа болоогүй, 9 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар харьяа 14 байгууллагад Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,765.2 сая төгрөгийн зөрчил илэрч, 5 байгууллагад 6.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж, 9 байгууллагад 1,759.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн байна. Өмнөх онд 3,364.9 сая төгрөгийн зөрчил илэрч 14 албан шаардлага өгч, 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулж байсан бол тайлант онд Шилэн дансны зөрчлийн дүн 47.7 хувиар буурчээ.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн тайлангийн аудитыг нийцлийн аудиттай хослуулан худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаж буй эсэхэд горим сорил хэрэгжүүлэхэд 4 төсвийн захирагч худалдан авах ажиллагааны хууль тогтоомж зөрчсөн 260.4 сая төгрөгийн зөрчил гаргасан байна.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын хийгээгүй.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	0	1	0	52.3
Зөвлөмж	1	21.1	0	0	0
Нийт дүн	3	21.1	1	0	17.4

Өмнөх аудитаар өгсөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах албан шаардлагын биелэлт 52.3 хувьтай хэрэгжсэн бол ЦСҮТ ОНӨҮГ-ын газрын захиралд хариуцлага тооцоогүй, тус байгууллага орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байна.

Санхүү, Төрийн сангийн хэлтсээс ЦСҮТ ОНӨҮГ-ын орлогын төлөвлөгөөнд авлагын үлдэгдлийг нэмж баталж байгаа нь жил бүр орлого тасрах шалтгаан болж байна.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад илэрсэн алдаа зөрчил:

Аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 14 төсвийн байгууллага, 5 ОНӨААТҮГ, тусгай сан 8, 3 төсвийн төвлөрүүлэн захирагч нийт 30 тайлан нэгтгэгдсэнээс 15 байгууллагад дүгнэлт гаргаж, 15 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”-10, “хязгаарлалттай”-4 /ЦСҮТ ОНӨҮГ/, /Баянтал сумын ЗДТГ/, /Баянтал сумын төвлөрүүлэн захирагч/, /Сүмбэр сумын Төвлөрүүлэн захирагч/, “Татгалзсан”-1 /Энхтүсдэм ӨЭМТ/ санал дүгнэлт тус тус өгчээ.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 5,736.3 сая төгрөгийн 162 алдаа зөрчил илрүүлэн, 26.7 хувь буюу 1,532.9 сая төгрөгийн 50 алдааг аудитын явцад залруулж, 45.3 хувь буюу 2,601.0 сая төгрөгийн 36 зөрчлийг арилгах албан шаардлага, 0.6% буюу 34.4 сая төгрөгийн 22 төлбөрийн акт тогтоож, 27.3 хувь буюу 1,568.0 сая төгрөгийн 52 зөрчлийг арилгах зөвлөмж, 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага өгсөн байна.

Нийцлийн аудиттай холбоотой зөрчил нийт зөрчлийн 2,849.0 сая төгрөг буюу 49.67 хувийг эзэлж байна.

Хүснэгт 13. Харьяа байгууллагад илэрсэн алдаа зөрчлийг өмнөх онтой харьцуулбал

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Тайлант он		Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал		Зөрүү	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Залруулга	57	6,725.2	50	1,532.9			(7)	5,192.3
Залруулаагүй алдаа	0	0					0	0
Төлбөрийн акт	16	11.9	22	34.4	2	2.2	6	22.5
Албан шаардлага	40	4,205.8	38	2,601.0	19	2,100.0	(2)	(1,604.8)
Зөвлөмж	44	798.1	52	1,568.0	24	746.7	8	769.9

Нийт	157	11,741.00	162	5,736.30	45	2,849.00	5	(6,004.7)
------	-----	-----------	-----	----------	----	----------	---	-----------

(Эх сурвалж: ТАБ-ын статистик мэдээ)

Хүснэгтээс харахад: Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад илэрч буй алдаа, зөрчил өмнөх оноос (6,004.7) сая төгрөгөөр буюу 49 хувиар буурсан байна.

Шилэн дансны алдаа зөрчил өмнөх 1,605.9 сая, аудитаар хийсэн залруулга 5,192.3 сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлжээ.

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ-НЭГТГЭСЭН ТАЙЛАНТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 66.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 20.2 сая төгрөгийн алдааг залруулж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой 46.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,354.5 сая төгрөгийн санхүүгийн зөрчил илэрсэн бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн тайланд аудитын хийгдээгүй 640.6 сая төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлсэн бөгөөд бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 285.5 сая төгрөгөөс хэтэрсэн тул **ХЯЗГААРЛАЛТТАЙ** санал дүгнэлтийг хүргүүлээ.

Мөн Сүмбэр, Баянтал сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн. Сумдын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгөхөд Сүмбэр сумын Энхтүсдэм ӨЭМТ татгалзсан, Баянтал сумын ЗДТГ хязгаарлалттай дүгнэлт авсан нь нөлөөлжээ. Эдгээр нь аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг хэмжээний боловч өргөн тархаагүй гэж үзсэн тул хязгаарлалттай дүгнэлт өгсөн болно.

Аудитаар нийт 20.2 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулсан. Үүнд

1. "Талын Илч" ОНӨААТҮГ мөнгөн гүйлгээний тайланд бусад мөнгөн орлогыг бараа борлуулсан үйлчилгээ үзүүлсэн орлогоор, "Илчлэг шивээ" ОНӨААТҮГ даатгалын нөхвөрөөс хүлээн авсан орлогыг бусад орлогоор тус тус тайлагнасан.

Аудитаар нийт 46.6 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 8.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 37.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Төсөвт төвлөрүүлэх ёстой 8.8 сая төгрөгийн түрээсийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх ёстой түрээсийн орлогыг бүрэн төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

5.2.1 Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. /Цөм сүрэг үржлийн төв, Сум дундын ойн ангийн өөрийн орлогыг бодитой төлөвлөгөөгүйгээс орлогын төлөвлөгөө 21,720.4 мянган төгрөгөөр биелээгүй/.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна”, 19.2-т “Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг тус тус **хэрэгжүүлж ажиллаагүй** байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, орлогын төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж батлуулах, орлогын төлөвлөгөөний биелүүлэлтэд хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.2.2 Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн Авто замын сангийн урьдчилгаа дансанд бүртгэлтэй 16.0 сая төгрөгийн он удаан жил хуримтлагдсан авлагыг бууруулах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна”, 19.2-т “Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг ба авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн авто замын санд бүртгэлтэй 16,045,247.0 /Арван зургаан сая дөчин таван мянга хоёр зуун дөчин долоон төгрөг/-ийн урьдчилгаа төлбөрийн авлагыг бууруулах ажлыг зохион байгуулах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Аймгийн Засаг даргын 2018 оны А/167-р захирамжаар баталсан аймгийн хэмжээнд мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хууль, тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлтэд нийцүүлэн шинэчлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, 19 дүгээр зүйлийн 19.1 “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”, 20 дугаар зүйлийн 20.2.2 “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн

бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Аймгийн хэмжээнд мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлттэй уялдуулан шинэчлэн боловсруулж батлах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан чиг үүргийн хүрээнд бодлогын баримт бичиг шинэчлэн боловсруулах үйл ажиллагаанд өөрийн нөөц боломжийг ашиглах, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулахгүй байх

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг даргад зөвлөж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Говьсүмбэр аймгийн Засаг дарга	1	20.2			1	20.2	1	20.2				
Дүн	1	20.2			1	20.2	1	20.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Говьсүмбэр аймгийн Засаг дарга	4	46.6	1	8.8	2	37.8	1						
Дүн	4	46.6	1	8.8	2	37.8	1						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

№	Байгууллага нэгжийн нэр	Байгууллагын регистрийн дугаар	2023 оны санхүүгийн тайлангийн аудит					Дүгнэлт		
			ҮАГ	АНАГ	АХЭ	Түүвэрт	Дүгнэлт гараагүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Татгалзсан
1	Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар	9018611		1				1		
2	"Аймгийн Цөм сүргийн үржлийн төв" ОНӨҮГ	4611918		1					1	
3	Сүмбэр сумын Засаг дарга	9018611		1					1	
4	Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	4614194		1		1				
5	Сүмбэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	9018964		1		1				
6	Говьсүмбэр аймгийн Ахмадын хороо	8239584		1		1				
7	Сүмбэр сумын Сум хөгжүүлэх сан	9018611		1		1				
8	Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сан	9018611		1		1				
9	Говьсүмбэр аймгийн Халамжийн сан	9019308		1		1				
10	Шивээговь сумын Засаг даргын тамгын газар	9018441		1				1		
11	Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	9018387		1		1				
12	Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сан	9018441		1		1				
13	Шивээговь сумын Сум хөгжүүлэх сан	9018441		1		1				
14	Говьсүмбэр аймгийн Сум дундын ойн анги	8131953		1		1				
15	Шивээговь сумын Засаг дарга	9018441		1				1		
16	Баянтал сумын Засаг даргын тамгын газар	9018522		1					1	
17	Баянтал сумын ИТХ	9018867		1		1				
18	Баянтал сумын Засаг дарга	9018522		1					1	
19	Баянтал сумын Орон нутгийн хөгжлийн сан	9018522		1		1				
20	Баянтал сумын Сум хөгжүүлэх сан	9018522		1		1				
21	Аймгийн Засаг даргын Тамгын газар	9018948		1				1		
22	Говьсүмбэр аймгийн Орон нутгийн өмчийн газар	4614909		1		1				
23	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	9018948		1		1				
24	Говьсүмбэр аймгийн Тохжилт Сүмбэр ОНӨААТҮГ	2005093		1				1		
25	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	9018662		1				1		

26	Говьсүмбэр аймгийн Талын илч ОНӨААҮГ	2005166			1			1		
27	Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Энхтүсдэм ЗГБХН өрхийн ЭМТ	2005344			1					1
28	Говьсүмбэр аймгийн Илчлэг-Шивээ ОНӨААТҮГ	2005123			1			1		
29	Говьсүмбэр аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар	9019197			1			1		
30	Ус-Ду ОНӨААТҮГ	2004933			1			1		
Бүгд			0	25	5	15	0	10	4	1